



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/326

Улаанбаатар хот

「Бүтэц, орон тоог баталж, албан хаагчдыг」
ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 26.3 дахь хэсэг, 43 дугаар зүйлийн 43.3.4 дахь заалт, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 21, 24 дүгээр зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 24 дүгээр тогтоол, “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай” 277 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2015 оны 633 дугаар захирамж, “Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрэм”-ийн 2.5.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөж байгаатай холбогдуулан хэлтсүүдийн чиг үүргийг нэгдүгээр хавсралтаар, хэлтэс, нэгжүүдийн бүтэц, орон тоог хоёрдугаар хавсралтаар, албан хаагчдын албан тушаалыг гуравдугаар хавсралтаар, албан хаагчдын цалин, нэмэгдлийг дөрөвдүгээр хавсралтаар 2019 оны 09 дүгээр сарын 23-ны өдрөөс тус тус шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан бүтэц, зохион байгуулалтын дагуу албан хаагчдын ажил үүргийн хуваарь, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлуулах, ажлыг ажил хүлээлцэх журмын дагуу хүлээлцүүлэх, гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээг шинэчлэх ажлыг зохион байгуулахыг хэлтэс, нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Батлагдсан төсөвт багтаан албан хаагчдыг ажиллах нөхцөлөөр хангах, өрөө тасалгааг хуваарилах, цалин нэмэгдлийг олгох, холбогдох тооцоог хийхийг


Тушаал-2019

115050001113

орлогч дарга /Д.Төмөрбаатар/, Ерөнхий нягтлан бодогч /Н.Уранчимэг/ нарт зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны Б/23 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

~~ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ~~



Ш.ҮНЭНБАТ